

ОНГОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
06 ДУГААР САРЫН МЭДЭЭ

2022.06.30

Хавирга

Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:

Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Тамгын газар, төрийн удирдлагын ажлын чиглэлээр

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид Уулбаян суманд зохион байгуулагдсан уулзалтад бүрэн хамрагдсан.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс, сумын Тамгын газар хамтран ХШҮ-ний бүсийн сургалтыг амжилттай зохион байгуулсан./Баруун уртын ЗДТГ, Түвшинширээ, Түмэнцогтын ЗДТГ-ын бүрэлдэхүүн оролцсон/

Тамгын газрын ил тод байдлын мэдээллийн самбарыг хос бичгээр шинэчлэн хийж, байршуулсан.

Иргэний танхимын хурлын ширээ, сандал, проекторыг шинэчилсэн.

ТАХ-чид, иргэдийг тоон гарын үсэгт нэвтрүүлэх ажил үргэлжлэн явагдаж байна.

Хоёр. Эдийн засаг төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:

Монгол улсын Засгийн удирдлага мэдээллийн цахим сүлжээг ашиглан төсвийн байгууллагуудын төлбөр тооцоог өдөр тутам хийж гүйцэтгэн холбогдох тайлан мэдээнүүдийг тогтмол гарган өгч байна.

Хөдөө аж ахуйн тооллогыг зохион байгуулж тайлан, дүнг статистикийн газарт хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын байцаагчтай тухай бүр тооцоо нийлж, өр авлагагүй ажилласан.

Сар бүрийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ, төрийн сангийн мэдээ, өглөг авлагын мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж цахим сүлжээгээр дамжуулан төрийн сангийн хэлтэст өгсөн.

Гурав. Хууль эрх зүйн бодлогын хүрээнд:

Хууль, тогтомж, тогтоол шийдвэрийн 2022 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг төрийн мэдээллийн үйлчилгээний цахим системд байршуулсан.

Тамгын газрын сул орон тооны захиалгыг Төрийн албаны салбар зөвлөлд явуулан төрийн албан хаагчийн тусгай шалгалтад 5 албан хаагч хамруулж, баталгаажуулсан.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар Энтерпренершип боловсрол олгох төслийн шалгаруулалтыг зохион байгуулж, 2 төсөл дэмжигдсэн.

Элсэлтийн ерөнхий шалгалтад 6 сурагч 600-аас дээш оноотой шалгагдаж, сурагч Г.Эрдэнэтулга Ерөнхийлөгчийн тэтгэлэгт хамрагдах болзолыг хангасан.

Хамтарсан багаас 2 иргэнийг архины албадан эмчилгээнд хамруулж, архины хамаарлаас холдуулах ажлыг зохион байгуулсан.

Эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэг, ЗДТГ, ОНӨААҮГ “тохилог орчин-хөгжлийн эхлэл” уралдаанд идэвхтэй оролцож засвар тохижилтын олон ажлыг хийж гүйцэтгэсэн.

Сумын төвийн халуун усыг ашиглалтад оруулж, иргэд халуун усны үйлчилгээ авах боломжтой болсон.



Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөлтэй хамтран “Цэцэрлэгт хүрээлэн” байгуулах ажлыг эхлүүлэн хашаа татах ажлыг хийсэн.



Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд:

Сумын төвд 4 га газарт 7 иргэн хүнсний ногоо тариалах ажил, 2 өрх жимс, жимсгэнэ тариалсан.

Сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор иргэнд газрыг олгон “Мод үрсэлгээний байгууламж”-ийг байгуулж 1300 мод суулган, ургалт хэвийн явагдаж байна.



Зорилтот бүлгийн иргэдээр Нийтийг хамарсан 10 хоногийн ажил зохион байгуулж, Хавиргын булаг, Мах үйлдвэрийн байгууламжийн хашаа, Наадамын талбай зэрэг газруудыг цэвэрлүүлсэн.

Хавиргын булгийн орчинд их цэвэрлэгээ хийж, хилийн 0184 дүгээр ангитай хамтран машины зогсоол, иргэд ус авахад зориулсан гоожуурыг шинээр хийсэн.



МЭДЭЭ БОЛОВСРУУЛСАН:
ХЭЗ-Н МЭРГЭЖИЛТЭН



С.АЗБИЛЭГ